



**ШУДАРГА БАЙДЛЫН СУДАЛГАА
ҮНДЭСНИЙ БӨХ ДЭХ ЁС ЗҮЙ,
АВЛИГЫН АСУУДЛУУД**

**2019 оны 7 сар
Улаанбаатар хот**

Үндэсний бөхийн шударга байдлын талаарх төсөөлөл

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчийн хамаарах бүлэг

#	Хариулт	НИЙТ	Цолтон	Дэмжигч
1	Үндэсний бөхийн (сэтгүүлч, судлаач, холбоонд хамаарах) мэргэжилтэн	4.4%	0.0%	7.8%
2	Үндэсний бөхийн улсын цолтон	1.9%	4.4%	0.0%
3	Үндэсний бөхийн аймаг, цэргийн цолтон	15.2%	35.3%	0.0%
4	Үндэсний бөхийн сумын цолтон	25.9%	60.3%	0.0%
5	Үндэсний бөхөөр хичээллэгч	2.5%	0.0%	4.4%
6	Үндэсний бөхийн багш, дасгалжуулагч	0.6%	0.0%	1.1%
7	Үндэсний бөхийн дэмжигч, фанат	48.7%	0.0%	85.6%
8	Ажиглагч	0.6%	0.0%	1.1%
#	НИЙТ	100.0%	100.0%	100.0%

График 1. Судалгааны дүнг харьцуулалт хийх бүлэг





График 2. Үндэсний бөхийн барилдаанууд хэр шударга болдог гэж та боддог вэ?



Судалгаанд оролцогчдын 52% буюу 2 хүн тутмын нэг нь “дунд” үнэлгээ өгчээ. Үүнийг шударга зүйл ч байгаа, шударга бус зүйл ч байна гэсэн төвийг сахисан хариулт гэж ойлгож байна.

Дээрх үр дүнгээс дундаж үнэлгээг тооцож үзвэл:

График 3. Шударга байдлын дундаж үнэлгээ



Нийт 1-5 оноогоор дүгнэх учир 3 оноо дундаж үнэлгээ юм. 3 онооны босгоор харьцуулж харвал дэмжигчдийн хувьд шударга бус талруугаа хэлбийсэн буюу дундаас доош үнэлгээ, цолтонуудын хувьд дундаас дээш үнэлгээтэй байна.

График 4. Хамгийн ёс зүйгүй, шударга бус үйлдэл, Нийт





График 5. Хамгийн ёс зүйгүй, шударга бус үйлдэл, Цолтон



График 6. Хамгийн ёс зүйгүй, шударга бус үйлдэл, Дэмжигч




Судалгаанды оролцогчдын дийлэнх хувь нь буюу 5 хүн тутмын дөрөв нь найраа хийх болон сэргээшийн асуудлууд шударга бус, ёс зүйгүй явдал гэж үзжээ. Цолтонуудын

хувьд сэргээшийг хамгийн өндөр хувьтай нэрлэсэн бол дэмжигчдийн хувьд найрааны асуудлыг хамгийн өндөр хувьтай нэрлэсэн байна.

Үндэсний бөх дэх найрааны асуултын үр дүн

График 7. Цол, даваа наймаалцах, найраа хийх үйлдэл хэр түгээмэл байдаг вэ?



Судалгаанд оролцогчдын 2.5% нь байхгүй буюу найраа хийгддэггүй гэж хариулжээ. Тэдгээр нь бүгд цолтонгууд байна. Эсрэгээр 40% нь түгээмэл буюу найраа байнга хийгддэг гэж хариулжээ. Энэ үзүүлэлт дэмжигчдийн хувьд цолтонуудаас илүү байна.

Дээрх үр дүнгээс дундаж үнэлгээг тооцож үзвэл:

График 8. Найрааны түгээмэл байдлын үнэлгээ



Дундаж үнэлгээнээс харахад найрааны асуудлыг цолтон, дэмжигч аль аль нь түгээмэл талруугаа хэлбийсэн гэж үзжээ. Дэмжигчдийн хувьд найрааны асуудал түгээмэл гэж үзэх хандлага их байна.

График 9. Улсын цолны даваа наймаалцах, найрааны ханшийн талаар




График 10. Аймаг, цэргийн цолны даваа наймаалцах, найрааны ханшийн талаар





График 11. Сумын цолны даваа наймаалцах, найрааны ханшийн талаар



Судалгааны оролцогчдын 50% орчим нь найрааны ханшийг ямар нэг байдлаар тодорхойлж байна. Бодитоор эсвэл төсөөллөөр тодорхойлсоныг мэдэх боломжгүй ч ямар нэг байдлаар ханш тодорхойлж байгаа нь найраа хэр түгээмэл байгаагийн нэг илрэл юм.

Цолтонуудыг илүү ойр, бодитоор үнэлж буй гэж үзээд, дэмжигчдийг төсөөллөөрөө үнэлж байна гэж үзвэл дэмжигчдийн төсөөллөснөө илүү мөнгө найраанд эргэлддэг болох нь харагдаж байна.

График 12. Цол, даваа наймаалцахад харилцааны хувьд дараахи хэлбэрүүдийн аль нь хамгийн нийтлэг вэ?





График 13. Цол, даваа наймаалцахад санаачлагын хувьд дараахи хэлбэрүүдийн аль нь хамгийн нийтлэг вэ?




Цол, даваа наймаалцах харилцааг дэмжигчдийн хувьд бөхчүүд өөрсдөө, багш дасгалжуулагч болон ивээн тэтгэгч гэсэн олон дамжлагын аль алинаар ойролцоо түвшинд явагддаг гэж үнэлсэн бол цолтонууд хувьд бөхчүүдийн хоорондоо тохиролцоо нь түгээмэл гэж хариулжээ.

Санаачлагчийн хувьд барилдаж буй бөхдөө даваа наймаалцахыг санал болгодог цолтонууд дийлэнх хувь буюу 10 хүн тутмын 6-7 нь ийм хариулт өгчээ. Дэмжигчдийн хувьд ойр дотны хүнээр дамждаг гэж тодорхой хувь нь үзэж байна. Үр дүн ийм зөрүүтэй

байгаа нь цолтонууд эсвэл дэмжигчид эсвэл аль аль нь төсөөллөөрөө хариулсан байх магадлалыг харуулж байна.

График 14. Цол, даваа наймаалцсан, найраа хийсэн бөхчүүдэд шийтгэл оногдуулдаг эсэх



Судалгаанд оролцогч 10 хүн тутмын 4 нь ямар нэг шийтгэл оногдуулдаг гэж үзэж байна. Энэ үр дүн нь нэг талаараа шийтгэл оногдуулдаг байх гэсэн төсөөлөлтэй, нөгөө талаараа ямар шийтгэл оногдуулбал зохилтой вэ гэдэг асуулттай ойролцоогоор ойлгосон байх магадлалтай юм.

Хүснэгт 2. Цол, даваа наймаалцсан, найраа хийсэн бөхчүүдэд ямар шийтгэл оногдуулдаг вэ?

#	Хариулт	НИЙТ	Цолтон	Дэмжигч
1	Хуулийн хариуцлага хүлээлгэх	10.1%	13.2%	7.8%
2	Барилдах эрхийг хасах	23.4%	20.6%	25.6%
3	Барилдах эрхийг хязгаарлах	11.4%	7.4%	14.4%
4	Цол, шагналыг хураах	25.3%	22.1%	27.8%
5	Мөнгөн торгууль оногдуулах	6.3%	5.9%	6.7%
6	Клуб, холбооны гишүүнчлэлээс хасах	1.9%	1.5%	2.2%
7	Ёс зүйн албадан сургалтанд хамруулах	3.8%	2.9%	4.4%
8	Олон нийтэд мэдээлэх	22.2%	19.1%	24.4%
9	Нийтээр жигших	4.4%	5.9%	3.3%
10	Сануулга өгөх	3.8%	2.9%	4.4%
11	Зэмлэх	0.6%	0.0%	1.1%
12	Шийтгэл оногдуулахгүй	44.9%	47.1%	43.3%
13	Мэдэхгүй	16.5%	16.2%	16.7%

Цол, даваа наймаалцах, найраатай холбоотойгоор ямар нэг шийтгэл хүртсэн тухай мэдээлэл одоогоор нийтэд төдийлөн мэдээлэгдээгүй байна. Харин сэргээштэй холбоотой асуудлуудын хувьд тодорхой хэмжээнд шийтгэл оногдуулдаг болох олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй мэдээллүүдээс харагддаг.

Хэдийгээр мэдээлэгддэггүй хэдий ч далд хэлбэрээр ямар нэг шийтгэл оногдуулдагийг үгүйсгэхгүй ч дээрх үр дүн судалгаанд оролцогчдын төсөөлөл байх магадлал өндөр юм.

График 15. Цол, даваа наймаалцсан, найраа хийсэн бөхчүүдэд шийтгэл оногдуулах эсэх



Судалгаанд оролцогчдын 90-ээс дээш хувь нь ямар нэг байдлаар шийтгэл оногдуулах нь зөв гэж үзэж байна. Цолтонуудын хувьд бараг бүгд буюу 1, 2 хүнээс бусад нь ямар нэг байдлаар шийтгэл оногдуулах нь зөв гэж үзэж байна.


Хүснэгт 3. Цол, даваа наймаалцсан, найраа хийсэн бөхчүүдэд ямар шийтгэл оногдуулбал зохилтой вэ?

#	Хариулт	НИЙТ	Цолтон	Дэмжигч
1	Хуулийн хариуцлага хүлээлгэх	38.6%	45.6%	33.3%
2	Барилдах эрхийг хасах	53.2%	52.9%	53.3%
3	Барилдах эрхийг хязгаарлах	28.5%	29.4%	27.8%
4	Цол, шагналыг хураах	53.2%	57.4%	50.0%
5	Мөнгөн торгууль оногдуулах	13.3%	14.7%	12.2%
6	Клуб, холбооны гишүүнчлэлээс хасах	6.3%	8.8%	4.4%
7	Ёс зүйн албадан сургалтанд хамруулах	10.1%	11.8%	8.9%
8	Олон нийтэд мэдээлэх	41.1%	35.3%	45.6%
9	Нийтээр жигших	5.1%	7.4%	3.3%
10	Сануулга өгөх	5.7%	7.4%	4.4%
11	Зэмлэх	0.6%	1.5%	0.0%
12	Шийтгэл оногдуулахгүй	4.4%	1.5%	6.7%
13	Мэдэхгүй	2.5%	0.0%	4.4%

Цол, даваа наймаалцах, найрааны асуудалд орсон бөхчүүдийн цол, шагналыг нь хураах, барилдах эрхийг хасах хэрэгтэй гэж судалгаанд оролцогч 2 хүн тутмын нэг нь үзэж байна.

Мөн судалгаанд оролцогч хүмүүсийн 5 хүн тутмын 2 нь олон нийтэд мэдээллэх хэрэгтэй гэж үзжээ. Энэ үр дүн найраатай холбоотойгоор шийтгэгдлээ гэсэн мэдээлэл бараг гарч байгаагүйтэй шууд холбоотой юм.

График 16. Цол, даваа наймаалцсан, найраа хийсэн бөхчүүдийн талаар гомдол хүлээж авах, шалгах, шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэдээлэх тогтолцоо бий юу? Хэр ажиллаж байна вэ?



Судалгаанд оролцогч 5 хүн тутмын 4 нь найраатай холбоотой асуудлыг мэдээллэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоо байхгүй, бий болгох шаардлагатай гэж үзжээ.

График 17. Цол, даваа наймаалцах, найраа хийх үйлдлийн учир шалтгааныг та юу гэж бодож байна вэ? Нийт



График 18. Цол, даваа наймаалцах, найраа хийх үйлдлийн учир шалтгааныг та юу гэж бодож байна вэ? Цолтон



График 19. Цол, даваа наймаалцах, найраа хийх үйлдлийн учир шалтгааныг та юу гэж бодож байна вэ? Дэмжигч



Нийт дүнгээр харахад найраа хийх гол учир шалтгаан нь бөхчүүдийн ёс зүй, жудаггүй байдал мөн амжиргааны асуудал гэж үзжээ. Энэ үр дүн дэмжигчдийн хувьд илүү түгээмэл бол цолтонуудын хувьд арай өөр шалтгааны түлхүү нэрлэсэн байна. Тэдгээрийг дурьдвал Ивээн тэтгэгчид, нутгийн зөвлөлтэй холбох, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй болон холбооны үйл ажиллагаатай түлхүү холбож байна.


Хүснэгт 4. Цол, даваа наймаалцах үйлдлийг таслан зогсоох, шударга өрсөлдөөнийг бий болгохын тулд ямар арга хэмжээ авбал зохилтой вэ?

#	Хариулт	НИЙТ	Цолтон	Дэмжигч
1	Үндэсний бөхийн тухай хуультай болох	48.1%	48.5%	47.8%
16	Цол, даваа наймаалцсан бөхчүүдийн цолыг хурааж, барилдах эрхийг хасах	30.4%	32.4%	28.9%
2	Үндэсний баяр наадмын тухай хуульд ёс зүй, авлигын асуудлуудыг нэмэлтээр оруулах	29.1%	33.8%	25.6%
3	Авлигын эсрэг хуульд спорт дахь авлигыг нэмж хуульчлах	24.1%	25.0%	23.3%
4	Үндэсний бөхийг мэргэжлийн спортын дүрэмтэй болгох	20.9%	27.9%	15.6%
5	Үндэсний бөхийг тогтмол улирал тутмын барилдаантай болгох	6.3%	7.4%	5.6%
6	Үндэсний бөхийн барилдааны дүрмийг өөрчлөх	14.6%	16.2%	13.3%
7	Үндэсний бөхийн барилдааны бай шагналыг нэмэгдүүлэх	12.0%	8.8%	14.4%
8	Үндэсний бөхийн цолыг улсаас биш холбооноос олгодог болгох	4.4%	2.9%	5.6%
9	Хөлийн цэцийг бөх биш хүмүүсээр бүрдүүлдэг болох	4.4%	4.4%	4.4%
10	Үндэсний бөхийн холбооны бүтэц удирдлагыг шинэчлэн байгуулах	7.6%	5.9%	8.9%
11	Ёс зүйн асуудлаар санал гомдол хүлээж авсан, шийдвэрлэсэн, хариуцлага тооцсон бүртгэлийг ил тод болгох	13.3%	11.8%	14.4%
12	Бөхчүүдийн холбоотой болох	5.1%	5.9%	4.4%
13	Бөхийн гал, клубүүдийг барилдааны бус үед мөрддөг ёс зүйн дүрэмтэй болгох	5.7%	4.4%	6.7%
14	Ёс зүйн алдаа гаргасан бөхчүүдэд барилдааны үеэр тэр дор нь арга хэмжээ авдаг болох	13.3%	11.8%	14.4%
17	Ёс зүйтэй, үлгэр жишээ бөхчүүдийг өргөмжлөх, алдаршуулах	7.6%	5.9%	8.9%
18	Үндэсний бөхийн фанатуудын зүгээс эсэргүүцлийн хөдөлгөөн өрнүүлэх	2.5%	1.5%	3.3%
19	Шударга өрсөлдөөний ач холбогдлыг сурталчлах ажил зохион байгуулах	3.2%	1.5%	4.4%
20	Юу ч хийгээд нэмэргүй	2.5%	4.4%	1.1%
21	Мэдэхгүй	0.6%	0.0%	1.1%
22	Бусад	2.5%	2.9%	2.2%

Үндэсний бөхийн тухай хуультай болох асуудлыг цолтон болон дэмжигчид аль аль санал нэгтгэйгээр хүлээн зөвшөөрч байна. Мөн ёс зүйн хариуцлага алдсан буюу найраа хийсэн, сэргээш хэрэглэсэн бөхчүүдийн цолыг хураах, шийтгэх асуудлаар арга хэмжээ авах шаардлагатайг цолтон, дэмжигчид аль аль нь илэрхийлсэн байна.

Шударга өрсөлдөөний талаар

График 20. Бөхчүүдийн ёс зүй, шударга байдлын хэм хэмжээ ямар түвшинд байна вэ?



Судалгаанд оролцогчдын 19% нь сайн үнэлгээ буюу 4-өөс дээш үнэлжээ. Тэдгээрийн дийлэнх хэсгийн цолтонууд бүрдүүлж байна.. Эсрэгээр 30% нь бөхчүүдийн ёс зүйн, шударга байдлын хэм хэмжээ муу буюу 2-оос бага үнэлгээ өгчээ. Тэдгээрийн дийлэнх

хувийг дэмжигчид бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл бөхчүүдийн ёс зүй, шударга байдлын хэм хэмжээг дэмжигчид цолтонгуудаа илүү муугаар үнэлж байна.


Дээрх үр дүнгээс дундаж үнэлгээг тооцож үзвэл:

График 21. Бөхчүүдийн ёс зүй, шударга байдлын хэм хэмжээний үнэлгээ



Дундаж үнэлгээнээс харахад бөхчүүдийн ёс зүй, шударга байдлын хэмжээг цолтонууд дунджаас бага зэрэг илүү үнэлсэн бол дэмжигчид дунджаас доогуур үнэлжээ.

График 22. Үндэсний бөхийн барилдаанд шударгаар амжилт үзүүлэх боломж хэр байна вэ?



Цолтонуудын 5 хүн тутмын нэг нь шударгаар амжилт үзүүлэх ямар ч боломж байхгүй гэж үзсэн бол дэмжигчдийн хувьд энэ үзүүлэлт 3 дахин бага байна. Судалгаанд оролцогч цолтонуудын 4 хүн тутмын нэг нь шударгаар амжилт үзүүлэх бүрэн боломжтой гэж хариулсан бол дэмжигчдийн 3 хүн тутмын нэг нь шударгаа амжилт үзүүлэл бүрэн боломжтой гэж хариулжээ.


Дээрх үр дүнгээс дундаж үнэлгээг тооцож үзвэл:

График 23. Шударгаар амжилт үзүүлэх боломжийн үнэлгээ



Дундаж үнэлгээнээс харахад цолтон, дэмжигч аль аль нь дундаас дээш үнэлгээ буюу шударгаар амжилт үзүүлэл боломж байгаа гэж үнэлжээ. Дэмжигчдийн хувьд үнэлгээ илүү буюу шударгаар амжилт үзүүлэл боломж их байгаа гэж үнэлсэн байна.

График 24. Үндэсний бөхийн ирээдүйг та хэрхэн төсөөлж байна вэ?



Үндэсний бөхийн ирээдүйг цолтонуудын 57% орчим нь сөргөөр харж байна. Өөрөөр хэлбэл цол, даваа наймаалцах, найрааны асуудал, сэргээшийн асуудал гэх мэт шударга бус байдлын асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй гэж үзэж байгаа ч шийдвэрлэнэ гэж бодохгүй, итгэхгүй байгаагийн илрэл энэ асуултын үр дүнгээс харагдаж байна.

Жудагтай бөх гэж ямар бөхийг хэлэх вэ гэсэн асуултад “шударга”, “элдэв асуудалд орооцолддоггүй”, “өв соёл, ёс заншлаа мэддэг”, “ёс зүйтэй” бөхийг хэлнэ гэж судалгаанд хариулт ирүүлсэн хүмүүс тодорхойлсон.

Энэхүү судалгааг цагаа олсон, зөв судалгаа гэж үнэлэх хэсэг байсныг энд дурдах хэрэгтэй.